ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 18 өдөр Дугаар 04/113 Жавхлант

Хяналтын ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын (орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам) 3 дугаар зүйлийн 3.4.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдэд үйлчлэх төвийн тохижилт, тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Эрдэнэцэцэг Санхүү албаны дарга

Гишүүдэд:

Н.Мөнхгэрэл Архив, бичиг хэргийн эрхлэгч

Ө.Дабааням Нягтлан бодогч

2.Захиалагчийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод үндэслэн хяналт тавьж, зургаар баталгаажуулж, хурлын тэмдэглэл, тайланг ирүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Т.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.БАТЧУЛУУН

D:Zasag darga /zahiramj-2025/